

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2016 оны 03 дугаар
сарын 23 -ны өдөр

Дугаар А/76, А/162

Улаанбаатар хот

Агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, бүсэд мөрдөх журам
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААЖ, ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон аймгийн Эрдэнэт хотын Агаарын чанарыг сайжруулах бүсийг нэгдүгээр хавсралтаар, Бүсэд мөрдөх журамыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангуулж, орон нутагтаа агаарын бохирдолтыг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс /Г.Батдэлгэр/ -д үүрэг болгосугай.


5. Энэхүү тушаал, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/ даалгасугай.

БАТЛАВ:
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД




Н.БАТЦЭРЭГ

БАТЛАВ:
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА БӨГӨӨД ЭРДЭНЭТ
ХОТЫН ЗАХИРАГЧ




С.ДАНГААСҮРЭН



Байгаль орчин, ногоон хөгжил, аялал
 жуулчлалын сайд Орхон аймгийн Засаг даргын
 хамтарсан 2016 оны 03 сарын 23-ны өдрийн
 ...296.69... тоот тушаал, захирамжийн 1 дүгээр хавсралт

**ОРХОН АЙМГИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ
 БҮСЭД ХАМРАГДАХ БАГУУД**

№	Хязгаарлалтын бүс	Бүсэд хамаарагдах газрын байршил, багууд	Эзлэх талбай /га/
1	Хязгаарлалтын I бүс	Булаг, Баянбулаг, Цагаанчулуут, Наран багууд, Дэнж багийн хойд хэсэг /3 байрны хойно байрлах гэр хороололтой хэсэг/	296.69
2	Хязгаарлалтын II бүс	Рашаант, Шанд, Даваат, Яргуйт, Их залуу багууд, Уртын гол багийн Эрдэнэт-Булганы авто замын хойд хэсэг	1247.00
3	Хязгаарлалтын III бүс	Эрдэнэ, Баянцагаан, Говил багууд, Дэнж, Уртын гол багуудын үлдсэн хэсэг	3138.60
4	Хотын төв буюу орон сууцны бүс	Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг, Бүрэнбүст, Уртбулаг, Согоот багууд, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан VII, VII ^a бичил хороолол, VIII хороололд хэрэгжиж буй "Эко хороолол"	422.60



ЭРДЭНЭТ ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ХЯЗГААРЛАЛТЫН БҮСЭД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрдэнэт хотын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа иргэд, үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд хязгаарлалтын бүс, агаарт үзүүлж буй нөлөөллөөс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн хэрэгцээндээ энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Журмыг Баян-Өндөр сум, багууд, хотын Захирагчийн алба, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар, Агаарын чанарын мэргэжлийн алба шууд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.

Хоёр. Иргэн аж ахуйн нэгж, байгууллага, хүлээх үүрэг

Хязгаарлалтын бүсүүдэд харъяагдаж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, түр болон байнгын оршин суугч иргэд агаарын бохирдлыг бууруулахад дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

2.1. Хязгаарлалтын нэгдүгээр бүс:

2.1.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэхдээ агаарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамааран Агаарын чанарын мэргэжлийн салбар албаар дүгнэлт гаргуулж, сумын Засаг даргаас зөвшөөрөл авах.(Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг)

2.1.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга байгууламжинд агаарын чанарт сөрөг нөлөөлөлгүй техник, технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, агаарын чанарын стандартыг мөрдөж ажиллана.

2.1.3. Аж ахуйн нэгж, байгууллагууд халаалтын сүүлийн үеийн, утаагүй техник технологи, тоног төхөөрөмж суурилуулж ашиглах, Агаарын чанарын мэргэжлийн салбар албанд бүртгүүлж, тодорхойлолт гаргуулна.

2.1.4. Халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд агаарт хаягдах бохирдолтыг бууруулах тоног төхөөрөмж суурилуулж, агаарын чанарын стандартыг мөрдөнө.

2.1.5. Түр болон байнгын оршин суугч иргэд гэр, барилга байгууламж/хувийн орон сууц/-ийн дулаан алдагдлыг багасгах зориулалттай барилгын материал, нэмэлт дулаалга, тоног төхөөрөмж хэрэглэнэ.

2.1.6. Иргэд ахуйн хэрэгцээндээ зөвхөн бүрэн шаталттай, сайжруулсан зуухыг ашиглалтын горимын дагуу ашиглаж, зуухны шаардлагыг хангасан түлш хэрэглэнэ..

2.1.7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд орчны ногоон байгууламжаа хамгаалах, арчлах, өөрийн эзэмшиж, өмчилж авсан газартаа 5-аас доошгүй мод тарьж, ургуулах.

2.1.8. Үнс, хог хаягдлыг зориулалтын цэг буюу битүүмжлэл сайтай саванд хийж түр хадгалах, тээвэрлэж зориулалтын цэгт хаях, зориулалтын үйлчилгээний автомашинаар тээвэрлүүлэх.

2.1.9. Өөрийн эзэмшлийн нүхэн жорлонд ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийж, орчинд эвгүй үнэр гаргахаас урьдчилан сэргийлэх.

2.1.10 Агаарын тухай хууль, дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангаж, мөрдөх.

2.1.11. Мэргэжлийн байгууллага, сум, багаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд идэвхтэй оролцож, хөнгөлттэй олгосон зуух, халаалтын бусад эх үүсвэр, хөнгөлөлтийг зориулалтын дагуу гэрээ байгуулж ашиглах.

2.1.12. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааны явцад агаарын чанарт сөргөөр нөлөөлөх үзэгдэл бий болсон тохиолдолд энэхүү журмын 4.2-т заасан эрх бүхий этгээдэд үнэн зөв шуурхай мэдээлэх.

2.1.13. Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж, зохион байгуулах ажлын хэсэг/цаашид ажлын хэсэг гэх/, мэргэжлийн байгууллага, сум, багаас зохион байгуулж байгаа агаарын бохирдлыг бууруулах сургалт, сурталчилгааны ажилд идэвхитэй оролцох, бусдад танин мэдүүлэх, сурталчлах.

2.1.14. Үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд агаарыг хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авч ажиллах.

2.1.15. Агаарын тухай хууль тогтоомж, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын шийдвэр, улсын байцаагч, хэсгийн ахлагчийн шаардлагыг биелүүлэх.

2.2. Хязгаарлалтын хоёрдугаар бүс:

2.2.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэхдээ агаарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамааруулан Агаарын чанарын мэргэжлийн салбар албаар дүгнэлт гаргуулж, сумын Засаг даргаас зөвшөөрөл авах. (Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг)

2.2.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга байгууламжиндаа агаарын чанарт сөрөг нөлөөлөлгүй техник, технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, агаарын чанарын стандартыг мөрдөж ажиллана.

2.2.3. Аж ахуйн нэгж, байгууллагууд халаалтын сүүлийн үеийн, утаагүй техник, технологи, тоног төхөөрөмж суурилуулж ашиглах, Агаарын чанарын мэргэжлийн салбар албанд бүртгүүлж, тодорхойлолт гаргуулна.

2.2.4. Агаарын чанарт сөрөг нөлөөгүй, утаа багатай, стандартад нийцсэн боловсруулсан түлш сонгон хэрэглэнэ.

2.2.5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд орчны ногоон байгууламжаа хамгаалах, арчлах, өөрийн эзэмшиж, өмчилж авсан газартаа 5-аас доошгүй мод тарьж, ургуулна.

2.2.6. Үнс, хог хаягдлыг зориулалтын цэг буюу битүүмжлэл сайтай саванд хийж түр хадгалах, тээвэрлэж зориулалтын цэгт хаях, зориулалтын үйлчилгээний автомашинаар тээвэрлүүлнэ.

2.2.7. Өөрийн эзэмшлийн нүхэн жорлонд ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийж, орчинд эвгүй үнэр гаргахаас урьдчилан сэргийлнэ.

2.2.8. Агаарын тухай хууль, дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангана.

2.2.9. Ажлын хэсэг, мэргэжлийн байгууллага, сум, багаас зохион байгуулж байгаа агаарын бохирдлыг бууруулах сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох, бусдад сурталчлах.

2.2.10. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааны явцад агаарын чанарт сөргөөр нөлөөлөх үзэгдэл бий болсон тохиолдолд үнэн зөв шуурхай мэдээлэх.

2.2.11. Үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд агаарыг хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авч ажиллах.

2.2.12. Агаарын тухай хууль тогтоомж, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын шийдвэр, улсын байцаагч, хэсгийн ахлагчийн шаардлагыг биелүүлэх.

2.3. Хязгаарлалтын гуравдугаар бүс:

2.3.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэхдээ агаарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамааруулан Агаарын чанарын мэргэжлийн салбар албаар дүгнэлт гаргуулж, сумын Засаг даргаас зөвшөөрөл авах. (Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт)

2.3.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга байгууламжинд агаарын чанарт сөрөг нөлөөлөлгүй техник, технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, агаарын чанарын стандартыг мөрдөж ажиллана.

2.3.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь халаалтын сүүлийн үеийн, утаагүй техник технологи, тоног төхөөрөмж суурилуулж ашиглах ба Агаарын чанарын мэргэжлийн салбар албанд бүртгүүлж, тодорхойлолт гаргуулна.

2.3.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь орчны ногоон байгууламжаа хамгаалах, арчлах, өөрийн эзэмшиж, өмчилж авсан газартаа 5-аас доошгүй мод тарьж, ургуулах.

2.3.5. Үнс, хог хаягдлыг зориулалтын цэг буюу битүүмжлэл сайтай саванд хийж түр хадгалах, тээвэрлэж зориулалтын цэгт хаях, зориулалтын үйлчилгээний автомашинаар тээвэрлүүлэх.

2.3.6. Өөрийн эзэмшлийн нүхэн жорлонд ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийж, орчинд эвгүй үнэр гаргахаас урьдчилан сэргийлэх.

2.3.7. Ажлын хэсэг, мэргэжлийн байгууллага, сум, багаас зохион байгуулж байгаа агаарын бохирдлыг бууруулах сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох, бусдад танин мэдүүлэх, сурталчлах.

2.3.8. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааны явцад агаарын чанарт сөргөөр нөлөөлөх үзэгдэл бий болсон тохиолдолд энэхүү журмын 4.2-т заасан эрх бүхий этгээдэд үнэн зөв шуурхай мэдээлэх.

2.3.9. Үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь агаарыг хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авч ажиллах.

2.3.10. Агаарын тухай хууль тогтоомж, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын шийдвэр, улсын байцаагч, хэсгийн ахлагчийн хуульд заасан шаардлагыг биелүүлэх.

2.4. Хотын төв буюу орон сууцны бүс:

2.4.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэхдээ агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл/утаа, тоос, үнэр, дуу чимээ/-өөс хамааруулан Агаарын чанарын мэргэжлийн салбар албаар дүгнэлт гаргуулж, сумын Засаг даргаас зөвшөөрөл авах. (Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт)

2.4.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга байгууламжинд агаарын чанарт сөрөг нөлөөлөлгүй техник, технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, агаарын чанарын стандартыг мөрдөж ажиллана.

2.4.3. Орчны ногоон байгууламжаа жил бүр хамгаалах, арчилж ургуулах хэрэв ногоон байгууламжгүй бол өөрийн эзэмшиж буй нийт талбайн арваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний газарт ногоон байгууламжийг бий болгох ажлыг зохион байгуулна.

2.4.4. Агаарын тухай хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын шийдвэр, улсын байцаагч, хэсгийн ахлагчийн хуульд заасан шаардлагыг биелүүлэх.

Гурав. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хориглох зүйл

Хязгаарлалтын бүсүүдэд харъялагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно. Үүнд:

3.1. Хотын төв буюу орон сууцны бүс:

3.1.1. Агаарт утаа, тоос, үнэр, хэт өндөр давтамжтай дуу чимээ зэргээр сөрөг нөлөө үзүүлэх суурин эх үүсвэр, байнгын үйл ажиллагаа эрхлэх;

3.1.2. Үйлдвэрлэл, үйлчилгээнд агаарын чанарын стандартыг хангаагүй техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, ашиглах;

3.1.3. Агаарын чанарын мэргэжлийн салбар албаны дүгнэлтгүй бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг агаарын бохирдлын томоохон эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

3.1.4. Хаягдал зүйлс, амьтны сэг, дугуй, нийлэг уут, ашигласан тос, масло, бусад хог хаягдлыг шатааж устгах;

3.1.5. Хог хаягдлыг зориулалтын бус цэгт хаях, хог хадгалах түр цэгт ил задгай шатаах, устгах;

3.1.6. Хавар, намрын улиралд гудамж, талбайд хуучин өвс/борог өвс/ шатаах.

3.2. Хязгаарлалтын нэгдүгээр бүс:

3.2.1. Сайжруулсан зуухнаас бусад зууханд түүхий нүүрс түлэх;

3.2.2. Хаягдал зүйлс, амьтны сэг, дугуй, нийлэг уут, хуванцар, ашигласан тос, масло, хог хаягдал зэрэг зориулалтын бус бусад түлш түлэх;

3.2.3. Аж ахуйн нэгж, байгууллагууд хуучирсан технологитой нам даралтын уурын зуух, агаарын чанарын стандартыг хангаагүй техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, ашиглах;

3.2.4. Агаарын чанарын мэргэжлийн салбар албаны дүгнэлтгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг агаарын бохирдлын томоохон эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

3.2.5. Техникийн нөхцөл, галын аюулгүй байдлын шаардлага хангаагүй цахилгаан халаах хэрэгсэл ашиглах;

3.2.6. Хөнгөлтэй олгосон зуух, бусад халаалтын эх үүсвэр, дулаалгын материал, хөнгөлөлтийг зориулалт бусаар ашиглах, бусдад дамжуулах, худалдаалах;

3.2.7. Хатуу, шингэн хог хаягдлыг зориулалтын бус цэгт хаях, хөрс, орчинг бохирдуулах, ил задгай шатаах, устгах;

3.2.8. Хавар, намрын улиралд гудамж, хашаандаа хуучин өвс/борог өвс/ шатаах.

3.3. Хязгаарлалтын хоёр, гуравдугаар бүс:

3.3.1. Хаягдал зүйлс, амьтны сэг, дугуй, нийлэг уут, хуванцар, ашигласан тос, масло, хог хаягдал зэрэг зориулалтын бус бусад түлш түлэх;

3.2.2. Аж ахуйн нэгж, байгууллагууд хуучирсан технологитой нам даралтын уурын зуух, агаарын чанарын стандартыг хангаагүй техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, ашиглах;

3.2.3. Агаарын чанарын мэргэжлийн салбар албаны дүгнэлтгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг агаарын бохирдлын томоохон эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

3.2.4. Хатуу, шингэн хог хаягдлыг зориулалтын бус цэгт хаях, хөрс, орчинг бохирдуулах, ил задгай шатаах, устгах;

3.2.5. Хавар, намрын улиралд гудамж, хашаандаа хуучин өвс/борог өвс/ шатаах.

Дөрөв. Хязгаарлалтын бүсэд тавих хяналт

4.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Баян-Өндөр сум, багийн Засаг дарга, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газар, Агаарын чанарын мэргэжлийн салбар алба хяналт тавина.

4.2. Багийн Засаг дарга нь өөрийн нутаг дэвсгэртээ агаар бохирдуулагч эх үүсвэрийн мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийн сангийн өөрчлөлтийн тайланг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны дотор Агаарын чанарын мэргэжлийн салбар албанд хүргүүлнэ.

4.3. Хязгаарлалтын бүс дэх багуудын хэсгийн ахлагч нь агаарын бохирдлын хяналтын орон тооны бус байцаагч байх бөгөөд журмын хэрэгжилтэд өдөр тутам хяналт тавьж ажиллана.

4.4. Агаарын чанарын мэргэжлийн салбар алба нь шинжилгээ, судалгааны дүнд үндэслэн агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргана.

4.5. Агаар бохирдуулагч томоохон эх үүсвэртэй аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг "Агаарын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэгт заасны дагуу холбогдох албанд хүргүүлнэ.

Тав. Хязгаарлалтын бүс дэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох урамшуулал

5.1. Хагас коксжуулсан болон үртэсэн шахмал түлшний нэг тонн тутмын үнийг зах зээлийн зарчмаар зохицуулалт хийж, хязгаарлалтын бүсээс хамааруулан хангалтыг зохион байгуулна.

5.2. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хэрэгцээнд зориулан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксжуулсан түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур тавьж, хэрэгцээгээ хангасан тохиолдолд бодлогоор дэмжиж, дэмжлэг үзүүлнэ.

5.3. Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд оршин суугч айл өрхүүдэд Агаарын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1- 14.1.7-д заасан нөхцөл шалгуурыг хангасан тохиолдолд урамшуулал олгож болно.

5.4. Агаарын бохирдлын хяналтын орон тооны бус байцаагчдад ажлын үр дүнгээр улирлын урамшуулал олгоно.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд "Агаарын тухай" хуулийн 31 дүгээр зүйл, "Агаарын төлбөрийн тухай" хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.